



# ЗЭЭЛИЙН БАГЦ #2 ТАНИЛЦУУЛГА

ББСБ-ын зээлийн багцаар баталгаажсан зээл

Бидэнтэй холбоо барих:

Утас: +976-75779444

И-мэйл: [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

Вэбсайт: [www.orda.mn](http://www.orda.mn)

---

2022 оны 10 сар

# ГАРЧИГ


Макро эдийн засгийн нөхцөл байдал.....	2
Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын орчин.....	3
Банкны салбар.....	3
Хөрөнгийн зах зээл.....	4
Банк бус санхүүгийн салбар.....	4
Дүгнэлт.....	5
ОРДА-гийн тухай.....	7
Хувийн зээлийн багцын хөрөнгө оруулалт.....	8
Өмнөх гүйцэтгэл.....	10
Оролцогч талууд.....	10
Үнэт цаас гаргагчийн тухай - “Стэпп Финанс” ХХК.....	10
Батлан даагчийн тухай - “ОРДА Финанс ББСБ” ХХК.....	11
Барьцаа хөрөнгө - Зээлийн багц.....	12
Хөрөнгө оруулалтын үе шат.....	13
Хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд.....	14
Манай баг.....	15
Хууль эрх зүйн орчин ба эрсдэлийн удирдлага.....	17
Tax implication.....	17
Investment Disclaimer.....	17
Хавсралт 1. “ОРДА Финанс ББСБ” ХХК-ийн 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлан.....	19
Хавсралт 2. “ОРДА Финанс ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ.....	20
Хавсралт 3. “Стэпп Финанс” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ.....	21
Хавсралт 4. Хүү бодох аргачлал.....	22

# 1 | Макро эдийн засгийн орчин

Украйн, Орос улсуудын хоорондын зөрчилдөөн нь дэлхийн нийлүүлэлт болон худалдааны урсгалыг тасалдуулж, дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулж байгаа ба цар тахлын хямралаас сэргэж амжаагүй олон улсын эдийн засагт нөлөө нь бүр илүү хүчтэй мэдрэгдэж байна. Энэхүү зөрчилдөөнөөс үүдсэн хямрал түүхий эдийн зах зээл, дэлхийн худалдааны болон санхүүгийн салбаруудад голчлон нөлөөлж байгаа юм. Дайны нөлөө эдийн засгийн хямралд хүргэж байгаа ч, түүнтэй зэрэгцээд шатахуун болон хүнсний үнийн хурдтай өсөлтөөс шалтгаалан инфляц мөн огцом өсөж байгаа нь эдийн засагт ховор тохиолддог “Стагфляци” гэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Өндөр инфляц болон эдийн засгийн хямрал хоёр зэрэг явагдахыг Стагфляци гэж нэрлэдэг. Ийм үед Төв банкнууд эхлээд эдийн засгийн өсөлтийг дэмжих үү, эсвэл инфляцийг бууруулах уу гэсэн хэцүү сонголт гаргах хэрэгтэй болдог.

Инфляцийн эсрэг авдаг нийтлэг арга хэмжээ нь бодлогын хүүг өсгөх бөгөөд үүний үр дүнд зээлийн хүү өсөж, түүнээс улбаалан иргэдийн мөнгө зарцуулах хүсэл буюу зах зээл дээрх эрэлт буурснаар барааны үнэ буурдаг. Ихэвчлэн энэ нь эдийн засгийн үйл ажиллагааг удаашруулан, ажилгүйдлийн түвшнийг нэмэгдүүлж болзошгүй ч энгийн үед эдийн засгийн хямралд хүргэдэггүй. Гэсэн хэдий ч цар тахлын хөл хорио, хязгаарлалтуудаас үүдэн олон улсын эдийн засаг аль хэдийн хямралтай байгаа нь асуудлыг хүндрүүлж байгаа юм.



Энэ үзэгдэл Монгол гэх мэт дундаас бага орлоготой орнуудад асар хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

- Монгол улсын ДНБ-ий өсөлт 2021 оны хоёрдугаар улиралд 6.3 хувь байсан бол 2022 оны хоёрдугаар улиралд 1.9 хувь болж буурчээ.
- 2022 оны 8 сарын сүүлийн байдлаар Монгол улсын хэрэглээний үнийн индексийн өсөлт буюу инфляцийн түвшин 14.4 хувь болсон.
- 2022 оны 9 сарын байдлаар 1 ам.доллар 3,257 төгрөгтэй тэнцэж байгаа бол жилийн өмнө 2,848 төгрөгтэй тэнцэж байжээ. Энэ нь нэг жилийн дотор төгрөг ам.долларын эсрэг 14 хувиар суларсныг илэрхийлж байна. Ялангуяа сүүлийн саруудад гадаад валютуудын эсрэг төгрөгийн ханш сар, жилийн дунджаагаас илүү хурдацтай суларч байна.
- Монгол банк өнгөрсөн жил цар тахлын үеэр бодлогын хүүгээ 6 хувь болгон бууруулж байсан ч сүүлийн байдлаар инфляцийг бууруулах арга хэмжээний хүрээнд 12 хувь болгож өсгөв.

Эдгээр эдийн засгийн таагүй нөхцөл байдал болон мөнгөний тогтворгүй, хатуу бодлого нь зах зээл дээр тодорхойгүй байдлыг бий болгон, иргэдийн бэлэн мөнгө зарцуулах сонирхлыг бууруулж, улмаар эдийн засаг улам агшиж байна.

## 2 | Санхүү, хөрөнгө оруулалтын орчин

### а. Банкны салбар


2022 оны эхний хагас жилийн байдлаар банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 23.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өсжээ.

Эдийн засгийг сэргээх 10 их наядын хөтөлбөрийн эерэг нөлөөллийн үр дүнд банкнуудын хөрвөх чадвар нэмэгдэж, Төв банкны үнэт цаасны хөрөнгө оруулалт багассанаар банкны системийн нийт активт эзлэх зээлийн багцын хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

Энэхүү өөрчлөлтийн үр дүнд өмнөх оны энэ үетэй харьцуулахад банкнуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа бага зэрэг муудаж, банкны салбарын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь буурсан байна.

## b. Хөрөнгийн зах зээл


2022 оны эхний 9 сард Монгол улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 30 орчим хувиар, нийт арилжааны дүн 57 хувиар, өдрийн дундаж арилжааны дүн 85 хувиар тус тус буурчээ. Энэ нь 2022 онд хөрөнгийн зах зээлийн идэвх буурсан, мөн хөрөнгө оруулагчид эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдалд нээлттэй хувьцаа гэх мэт өндөр эрсдэлтэй хөрөнгөд хөрөнгө оруулах сонирхол багатай байгааг харуулж байна.



## c. Банк бус санхүүгийн /ББСБ/ салбар

2022 оны эхний хагасын байдлаар Монгол улсад 527 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 36 нь онлайн зээлийн платформ байна. ББСБ-уудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар өссөн бөгөөд үүнд өр төлбөрийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн нь ББСБ-ууд хувьцаа санал болгохоос илүүтэйгээр зээл, бондоор дамжуулан санхүүжилт татсаныг илтгэж байна.


Өрийн санхүүжилтийн өсөлт:



ББСБ-уудын нийт орлого 2021 оны 6 сараас 2022 оны 6 сар хүртэл 78.1 хувиар өссөн бол цэвэр ашиг 76.0 хувиар өсжээ. Энэ хугацаанд зээлдэгчдийн тоо 2 дахин нэмэгдэж, 1.5 сая орчим болсны 80 хувь нь Финтек ББСБ-уудаас онлайн зээлийн үйлчилгээ байна. Энэ нь технологи болон инноваци нь ББСБ-ын зах зээлийг хэрхэн өөрчилж байгааг, харилцагчдын хүсэл сонирхол мөн хаашаа илүү чиглэж байгааг харуулж байна.

Зургаадугаар сарын эцсийн байдлаар ББСБ-уудын нийт зээлийн багц өнгөрсөн оны мөн үеэс 58.9%-аар өсөж, 2.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт зээлийн багцын 90% нь хэвийн зээл байгаа нь нийт зээлүүдийн эргэн төлөлтийн 90% нь цагтаа хийгдэж байна гэсэн үг юм.

Ямартай ч ББСБ-ын салбар өргөжин тэлж, ихэнх зээлүүд бодит хөрөнгийн барьцаагүй жижиг, онлайн зээлүүд байгаа ч ерөнхийдөө хэвийн эргэн төлөлттэй байна.



#### d. Дүгнэлт

Дэлхийн эдийн засаг сүүлийн нэг жилийн хугацаанд агшсаар байна. Үүнд хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнийн бууралт, өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын инфляцийн эсрэг авч буй арга хэмжээ болох бодлогын хүүгийн өсөлт, засгийн газрын бондын өгөөжийн өсөлт зэрэг голлон нөлөөлжээ.

Хэрэв өндөр хөгжилтэй орнуудын төв банкууд мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлсээр байвал засгийн газрын бондын өгөөж нэмэгдэн, санхүүгийн нөхцөл байдал улам хүндэрч, хөгжиж буй орнуудаас хөрөнгийн гадагшлах урсгал ихэснээр валютын ханш сулрах дарамтыг нэмэгдүүлнэ. Дэлхийн дахинаа санхүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа нь ялангуяа хөгжиж буй орнуудын эдийн засагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Гэсэн хэдий ч Монгол улсын хувьд шинэ бизнес эрхлэгчдийн тоо өмнөх оны мөн энэ үеэс 8.1 хувиар өссөн ба үүнтэй зэрэгцээд өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан, бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлүүд илүү өндөр хүүтэй болоод байна. Бизнес эрхлэгчдийн орлого буурснаар чанаргүй зээлийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж байгаа ба үүнийг банкнуудын эрсдэлийн үүднээс авч үзвэл банкнууд шинэ зээлдэгчдэд олгох зээлийн бодлогоо чангатгах хандлагатай байна.

Энэхүү банкуудын бизнесийн салбарт зориулсан зээлийн хэмжээ буурсан нь Монголын Хөрөнгийн Бирж, ББЗЗ гэх мэт зохицуулалттай зах зээл дээр санал болгож буй компанийн өрийн бичиг болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-аарх санхүүжилт өсөхөд хүргэсэн. 2022 оны 2 дугаар хагасын байдлаар нийт энэ төрлийн санхүүжилтын хэмжээ 173.6 тэрбумд хүрсэн байна.

Иймд, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын дээрх хүчин зүйлүүд болон сүүлийн үеийн санхүүгийн чиг хандлагад нийцүүлэн бид та бүхэнд тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтыг санал болгож байна.



## 3 | ОРДА-гийн тухай

ОРДА бол хөрөнгө оруулагчдад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, урлагийн бүтээл, ховор цуглуулга, дижитал хөрөнгө зэрэг уламжлалт бус, бодит хөрөнгүүдэд (альтернатив хөрөнгө) хэсэгчилсэн байдлаар хөрөнгө оруулах боломж олгодог, технологид суурилсан платформ юм. Бид мэргэжлийн болон жижиг хөрөнгө оруулагчдад хил дамнасан хөрөнгө оруулалтын татвар, хууль эрхзүйн аливаа хүндрэлүүдийг бууруулах замаар уламжлалт болон уламжлалт бус хөрөнгө оруулалтын хоорондох заагийг арилгахаар зорин хөгжүүлэлтээ хийж байна.

Манай компанийн зорилго нь хөрөнгө оруулалтыг илүү хүртээмжтэй, эрх тэгш ардчилсан болгох бөгөөд өмнө нь зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон чинээлэг иргэдийн хөрөнгө оруулдаг байсан ховор бөгөөд тансаг виски, дарс, урлагийн сор бүтээл гэх мэт онцгой, бодит хөрөнгүүдэд хүн бүр өөрсдийн хэмжээ, эрсдэлийн хүрээнд хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэхэд оршино. Бид технологи болон инновацилаг бизнес загварын тусламжтайгаар хүмүүст тэр бүр нээлттэй биш байсан боломжуудыг нээж, өөрийн санхүүгийн бололцоондоо тохируулан хуримтлал үүсгэх арга замыг бий болгож чадна гэж итгэдэг.



ОРДА нь хөрөнгийн зах зээлд энэхүү шинэлэг санаагаараа Цахиурын хөндийн нэр хүндтэй, олон улсын тэмцээнүүдийн нэг Startup World Cup-т оролцож, бүсийн шилдэг 10 стартапын нэгээр шалгарсан бөгөөд БНСУ-ын засгийн газрын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг K-Startup Grand Challenge 2021 хурдасгуур хөтөлбөрийн шилдэг оролцогчдын нэгээр Монгол улсаас анх удаа амжилттай шалгарсан.

Мөн Орда аппликейшний бета хувилбар 6 дугаар сард нээлтээ хийсэн бөгөөд 4 сарын дотор 700 орчим хэрэглэгч манай хөрөнгө оруулалтын платформд нэгдээд байна.

Бид 2021 оны 3-р сараас эхлэн үл хөдлөх хөрөнгө, дээд зэрэглэлийн торхтой, лонхлосон вискинүүд, урлагийн бүтээл, NFT болон виски багц зэрэг 10 төрлийн хөрөнгийг хөрөнгө оруулагчдад амжилттай санал болгоод байна. Зарим хөрөнгө нь GBP эсвэл еврогоор илэрхийлэгдсэн ба жилийн өгөөж нь 14% - 30% бөгөөд зарим хөрөнгө оруулагчдад бэлэн мөнгөний ногдол ашиг тараасан.


Харин энэ удаа ОРДА нь “Орда Финанс ББСБ” /цаашид “ББСБ” гэх/-ын зээлийн багцаар баталгаажсан “Стэпп Финанс ХХК” /цаашид “Стэпп финанс” гэх/-иас олгосон хоёр дахь хувийн зээлийн багцын хөрөнгө оруулалтыг санал болгож байна.

## 4 | ЗЭЭЛИЙН БАГЦ

Валют	Төгрөг
Жилийн хүү	20.00%
Хугацаа	1 жил
Татан төвлөрүүлэх нийт дүн /Soft cap/*	100,000,000 төгрөг
Хүүний төлөлт	Улирал бүр
Хөрөнгө оруулах доод дүн	100,000 төгрөг

\* Soft cap - Төлөвлөж байгаа дүн бөгөөд үүнээс дээш эсвэл доош байж болно.

Бидний 2021 онд санал болгосон зээлийн багцын төгрөгийн транчийн жилийн хүү 17 хувь, Ам.долларын транчийн жилийн хүү 10.5 хувь байсан. Түүнээс хойш Монгол банк бодлогын хүүгээ 12 хувь болгон өсгөснөөр зах зээл дээрх зээлийн хүү илүү өндөр болсон тул бид энэ удаагийн багцдаа жилийн 20 хувийн хүү санал болгож байна. Орда зээлийн багцын хүүний түвшнийг Монголын зах зээл дээрх бусад нэг жилийн хугацаатай тогтмол өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдтэй харьцуулсан байдлыг доорх графикаас харна уу.



Түүнчлэн төгрөгийн ам.доллартой харьцах ханш улам суларч байгаа тул бид ам.доллароор зээл олгоход валютын эрсдэл хэт өндөр байна гэж үзэж, энэ удаа зөвхөн төгрөгийн санхүүжилт санал болгож байна. Гэсэн ч гадаад улсад оршин суугаа харилцагч нар энэхүү бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах боломжтой бөгөөд, гүйлгээ хийх үеийн арилжааны банкны самбарын ханшаар ханшаар ам.доллар төгрөгийн хөрвүүлэг хийгдэнэ.

Дараах хүснэгтэд хөрөнгө оруулалтын ялгаатай хэмжээнүүдэд хамаарах жилийн болон улирал тутмын хүүний орлогыг жишээ болгон харуулж байна:

Мянган төгрөгөөр

Хөрөнгө оруулах дүн	₮100	₮500	₮1,000	₮5,000	₮10,000	₮10,000	₮50,000
Улиралын хүү /татварын өмнөх/	₮5	₮25	₮50	₮250	₮500	₮500	₮2,500
Улиралын хүү /татварын дараах/	₮5	₮23	₮45	₮225	₮450	₮450	₮2,250
Жилийн хүү /татварын өмнөх/	₮20	₮100	₮200	₮1,000	₮2,000	₮2,000	₮10,000
Жилийн хүү /татварын дараах/	₮18	₮90	₮180	₮900	₮1,800	₮1,800	₮9,000

## Өмнөх гүйцэтгэл

2021 оны 10 дугаар сард бид ижилхэн бүтцээр анхны зээлийн багцын санхүүжилтээ санал болгож, нийт 17 хөрөнгө оруулагчаас 108 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн ба түүний 15% нь ам.долларын санхүүжилт байсан. Энэхүү хөрөнгө оруулалтыг анх танилцуулж байсны дагуу Орда финанс ББСБ-ын зээлийн багцыг нэмэгдүүлэхэд 100% зарцуулсан ба улирал бүр хүүний төлбөрөө хугацаанд нь амжилттай төлж дуусгасан.

# 5 | Оролцогч талууд

## 1. Үнэт цаас гаргагчийн тухай - “Стэпп Финанс” ХХК

Стэпп финанс нь татвар, санхүү, даатгалын зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах замаар компаниуд болон хувь хүмүүстэй хамтран ажилладаг ба үйлчлүүлэгчдэдээ датан дээр суурилсан анализ, дүн шинжилгээ хийх замаар богино, дунд, урт хугацааны санхүүгийн шийдвэр гаргахад тусалдаг.

Стэпп финанс нь 2021 оны 10-р сард Орда платформ дээрх анхны зээлийн багцыг санал болгон амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай.

1 Үйл ажиллагаа	Бизнесийн зөвлөгөө өгөх
2 Үүсгэн байгуулагдсан огноо	2018 оны 12 дугаар сарын 13
3 Компанийн регисрийн дугаар	6379664
4 Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уулдүүрэг, 15-р хороо, Галакситауэр, 605 тоот
5 Хувьцаа эзэмшигч	Батчулууны Гэрэлмаа – 100%

## 2. Батлан даагчийн тухай - “ОРДА Финанс ББСБ” ХХК

Орда финанс нь 2015 онд Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба Б.Гэрэлмаа нь 2020 онд тус компанийн эзэмшлийг 100% шилжүүлэн авсан.

Орда финанс уламжлалт зээлийн үйлчилгээг дижитал зээлийн үйлчилгээтэй хослуулан бизнесийн загвараа өөрчлөхөөр төлөвлөж байна. Ингэснээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг түргэн шийдвэрлэхээс гадна санхүүгийн сахилга батыг сайжруулж, улмаар санхүүгийн байдлаа дээшлүүлэхэд нь тус нэмэр болох зорилготой.

Финтекийн зах зээлийн судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, боломжит харилцагчдад санал болгох замаар зээлийн шинэ бүтээгдэхүүний турших зорилгоор одоогийн байдлаар Орда финанс нь зээлийн үйл ажиллагааг уламжлалт хэлбэрээр гүйцэтгэж байна.

Орда финанс нь Орда платформ дээрх хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хөрөнгийг багцаар нь барьцаалсан зээлийн шугам, зээлийн карт, мөн крипто болон дижитал хөрөнгөөр барьцаалсан дижитал зээлүүдийг олгох чиглэлээр зээлийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна.

1	Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа
2	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	2015 оны 6 дугаар сарын 10
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,900,000,000 /нэг тэрбум есөн зуун сая/ төгрөг
4	Компанийн регисрийн дугаар	5960711
5	Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уулдүүрэг, 15-р хороо, Галакситауэр, 605 тоот
6	Хувьцаа эзэмшигч	Батчулууны Гэрэлмаа – 100%
7	Ажилчдын тоо	5

- Санхүүгийн үзүүлэлт - 2022 оны 3-р улирал

Мянган төгрөгөөр

Нийт хөрөнгө	2,151,910.90
Өр төлбөр	151,263.20
Эздийн өмч	2,006,890.80
Хүүгийн орлого	128,760.60
Цэвэр ашиг	59,165.00
ROE	2.95%
ROA	2.75%

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Харьцаа үзүүлэлт	Зохистой хэмжээ	Гүйцэтгэл
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	> 10%	93.70%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	> 8%	38.90%
Өрийн бичгийн зохистой харьцаа	< 50%	0.00%

- Барьцаа хөрөнгө - ББСБ зээлийн багц

Мянган төгрөгөөр

<b>Зээлийн багц</b>	<b>1,653,859.94</b>
Иргэнд олгосон зээл	1,130,938.33
Хэрэглээнд зориулсан зээл	149,390.78
Бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл	910,464.60
Автомашин худалдан авахад зориулсан зээл	71,082.95
Хуулийн этгээдэд олгосон зээл	522,921.61
Бизнесийн зээл	478,130.85
Автомашинны зээл	44,790.76
Зээлийн дансны тоо	34
Зээлийн жигнэсэн дундаж сарын хүү	2.10%
Зээлийн дундаж хугацаа	24 сар

## 6 | Хөрөнгө оруулалтын үе шат

### 1-р алхам

QR код уншуулан ОРДА аппликейшнийг татаж, бүртгүүлэх;

### 2-р алхам

Аппликейшн дээрх хэрэглэгчийг таньж мэдэх /ХТМ/ хэсгийг бөглөн, илгээх;

### 3-р алхам

Аппликейшн дээрх "Хөрөнгө оруулах" таб руу орж "Зээлийн багц №2" дээр дарах;

### 4-р алхам

"Хөрөнгө оруулалт хийх" товчийг дарж, хөрөнгө оруулахыг хүсэж буй дүнгээ оруулах;

### 5-р алхам


Захиалгаа баталгаажуулах;

### 6-р алхам

Таны бүртгүүлсэн имэйл хаяг руу илгээсэн нэхэмжлэлийн дагуу хөрөнгө оруулалтын төлбөрийг хийх;

### 7-р алхам

DocuSign-аар дамжуулан таны бүртгэлтэй имэйл хаяг руу илгээсэн зээлийн багцын гэрээнд гарын үсэг зурах.



# 7 | Хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд

## 1. Зээлийн эрсдэл

Үнэт цаас гаргагч нь хүү болон үндсэн төлбөрийг хугацаа нь дуусах үед төлөх боломжгүй байх магадлал юм. Хөрөнгө оруулагчид төлбөрийн чадваргүй болох магадлалыг харгалзан үзэж, хөрөнгө оруулалтын шийдвэртээ энэ эрсдэлийг тооцох ёстой.

## 2. Инфляцийн эрсдэл


Инфляц нь маргаашийн мөнгөн тэмдэгтийг өнөөдрийнхөөс доогуур үнэлэхэд хүргэдэг; өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчийн ирээдүйн хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийн худалдан авах чадварыг бууруулдаг.

## 3. Хөрвөх чадварын эрсдэл

Хөрөнгө оруулагч өөрийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтыг бусдад худалдах тохиолдолд худалдан авагч олоход хүндрэлтэй байх эсхүл зах зээлийн үнээс их хэмжээгээр хямдруулан зарах шаардлага үүсэх эрсдэлтэй.

## 4. Бусад холбогдох эрсдэлүүд

Эдгээр эрсдэлүүдэд үүгээр хязгаарлагдахгүйгээр (i) хууль эрх зүйн эрсдэл, (ii) зах зээлийн эрсдэл, (iii) эдийн засгийн эрсдэл гэх мэт эрсдэлүүд хамаарна.



# 8 | Манай баг

## Үүсгэн байгуулагчид



**Гэрэлмаа. Б**  
CEO & Үүсгэн байгуулагч  
Бодлого, Технологи, Бизнес  
Инновацийн мастер, UVSQ, France  
Математикийн бакалавр, KAIST



**Peter Choe**  
CTO & Үүсгэн байгуулагч  
Финтек, CS, Стартап  
UPenn CS мастер, NYU бакалавр  
KAIST CS Докторын зэрэг. ABD

- 2021 **ADB** болон **Монгол банк** Зөвлөх  
Банкны систем, дижитал банкны дахин төлөвлөлт
- 2015- 2021 **Steppe Group** Гүйцэтгэх захирал  
Хүн төвтэй санхүү, технологийн компани
- 2019-2021 **AmCham Mongolia** ТУЗ  
ICT болон дижитал эдийн засгийн хорооны дарга
- 2013-2014 **OECD** Бодлогын шинжээч  
Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын орчны томоохон реформ дээр ажилласан
- 2013-2014 **UVSQ** Инновацийн мастер зэрэг  
Сэргээгдэх эрчим хүчний инновациар хэд хэдэн стартап
- 2008-2013 **KAIST** Бакалаврын зэрэг  
Математик болон Менежментийн шинжлэх ухааны хосолсон бакалаврын зэрэг

- 2016-2018 **UPMC** Ахлах системийн инженер  
Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах төсөл дээр ажилласан
- 2015-2016 **Seeds** CTO  
Barclays Techstars NYC стартапын хурдасгуур хөтөлбөрийн төгсөгч
- 2010-2012 **atDusk** CEO/Үүсгэн байгуулагч  
Судалгаан дээр үндэслэсэн технологийн төсөл
- 2004-2012 **KAIST** PhD ABD  
Томоохон HCI конференсуудад оролцсон (UbiComp, CHI, Mobile HCI and ACM Multimedia)

## Санхүүгийн баг



**А.Хэрлэнчимэг**  
CFO  
Санхүү, бодлого  
Глостерширийн их сургууль,  
Англи улс, M.B.A.



**Н. Буяндэлгэр**  
Сангийн менежер  
Санхүү, хөрөнгө оруулалт  
Азийн их сургууль, Тайвань  
Санхүү удирдлага, Бакалавр



**П.Пүрэвдулам**  
Санхүүгийн шинжээч  
СЭЗИС  
Санхүү удирдлага, Бакалавр

## Технологийн баг



**Vipul Bansal**  
Хөгжүүлэгч  
Пунжабын техникийн ИС, Энэтхэг  
Мэдээллийн технологи, Мастер



**М. Содгэрэл**  
Хөгжүүлэгч  
Нью-Йоркийн их сургууль, Абу Даби  
Компьютерийн ШУ, Бакалавр



**С. Сайханбилэг**  
Хөгжүүлэгч  
KAIST, БНСУ  
Компьютерийн ШУ, Бакалавр



## Үйл ажиллагааны баг



**Б. Солонго**  
COO  
Луизианагийн их сургууль, АНУ  
Бизнесийн удирдлага, Бакалавр



**Ж. Үүрийнтуяа**  
Үйл ажиллагааны менежер  
МУИС  
Санхүү удирдлага, Бакалавр



**Ж. Өлзийжаргал**  
Маркетингийн дадлагажигч  
Чунан Их сургууль, БНСУ  
Менежмент, Бакалавр

## Хуулийн баг



**Б. Хүслэн**  
Ахлах хуульч  
Рэнмин их сургууль, БНХАУ  
Хууль, Мастер



**Б. Баясгалан**  
Хуульч  
Сиднейн Их сургууль  
Эдийн засаг, Худалдааны  
хууль, Бакалавр

## Олон улсын зөвлөх баг



**Len Ball**  
Дижитал шилжилтийн менежмент  
Канадын банк санхүү, Стартап  
Уилфрид Лориер их сургууль,  
Мастер



**Sung Won Park**  
Нью Йоркийн хуульч  
JP Morgan Chase, Credit Suisse Санхүүч  
NYU Stern,  
Санхүү ба мэдээллийн технологи



**Charles Latchoumane**  
Тархи судлал, зан төлвийн  
санхүү  
KAIST, Мастер, Доктор



**Hyukjae Jang**  
БНСУ, Японы Лайн компанийн ахлах  
хөгжүүлэгч  
KAIST, Компьютерийн ШУ-ы Доктор



**Benny Lau**  
Хөрөнгө оруулалт, Дойче банк  
Прайм брокерийн Ази номхон  
далайн бүс хариуцсан захирал



**Joshua Foo**  
Бүсийн захирал, Chainalysis  
GovTech Сингапур

## 9 | Хууль эрх зүйн орчин ба эрсдэлийн удирдлага

Монгол улсад одоогийн мөрдөгдөж буй хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг “Стэпп финанс” ХХК гүйцэтгэн, удирдаж явуулах бүтцийг санал болгож байна.

### а. Татварын орчин

Худалдан авалт болон хөрөнгө оруулалттай холбоотой өгөөж ашгаас Монгол улсын хуулийн хүрээнд татвар төлөгдөнө. Татвартай холбоотой тооцоолол, бүртгэлтэй тайлангийн холбогдох хэсгээс танилцаж болно.

### б. Мэдэгдэл

- Ерөнхий

Орда багийн үүсгэсэн Орда Вэб сайт болон Орда Аппликешн дэх аливаа баялаг агуулга, хөрөнгийн жагсаалт, агуулга нь хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичиг биш бөгөөд түүний агуулга нь зөвхөн хөрөнгө оруулалтын боломжийн талаархи бололцоот хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн зорилгоор гаргасан болно. Вэбсайт эсвэл Аппликейшнд байх аливаа агуулгыг хөрөнгө оруулалтын зөвлөгөө гэж ойлгохгүй. Хөрөнгө оруулагчид зөвхөн өөрсдийн үзэмжээр шийдвэр гаргана.

Орда болон түүнтэй холбоотой талууд энд өгөгдсөн мэдээлэлд үндэслэн аливаа хүний шийдвэрийн улмаас учирсан хохирол, зардлыг хариуцахгүй. Бүх хөрөнгө оруулалтын стратеги, хөрөнгө оруулалт нь алдагдал хүлээх эрсдэлтэй байдаг. Өсөн нэмэгдэж буй зах зээлд ч гэсэн богино эсвэл урт хугацааны хэлбэлзэл үргэлж байдаг бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчид оруулсан бүх мөнгөө буцааж авах бүрэн баталгаа байхгүй гэсэн үг юм. Хөрөнгө оруулалтын өнгөрсөн болон боломжит гүйцэтгэлийн талаархи аливаа ишлэл нь зөвлөмж биш бөгөөд ямар ч байдлаар тодорхой үр дүн, ашгийн хувьд өгөх баталгаа гэж ойлгохгүй.

- **Гадаад хөрөнгө оруулагчид**

Орда Вэбсайт болон Орда багийн бүтээсэн Орда Аппликейшн дэх аливаа хөрөнгийн агууламж, хөрөнгийн жагсаалт, контент нь зөвхөн санал болгож буй хөрөнгө оруулалттай холбоотой мэдэгдэж байгаа болон үл мэдэгдэх эрсдэлийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн магадлан итгэмжлэгдсэн хөрөнгө оруулагчдад зориулагдсан. Орда нь үе үе магадлан итгэмжлэгдсэн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх боломжийг нээж болох боловч аливаа хөрөнгө оруулалтад ямар нэгэн тодорхой боломж хэр тохирох талаар ямар нэгэн зөвлөмж өгдөггүй. Эдгээр агуулгыг ашиглах нь Орда нь аливаа хөрөнгө оруулалт, үнэт цаас худалдах, худалдан авах санал гаргаж буй үйлдэл биш болно.

ORDA нь холбогдох дотоодын хууль тогтоомж эсвэл хөрөнгө оруулагчийн харьяалагдах улсын хуулийн дагуу хууль бус байх магадлалтай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, борлуулах зорилго байхгүй болно. Иймд гадаадын хөрөнгө оруулагчид өөрсдийн үзэмжээр өөрийн улс, хуулийн харьяалалд мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа хийх үүрэгтэй. ОРДА нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын шийдвэрт шууд болон шууд бусаар хариуцлага хүлээхгүй.

## Хавсралт 1. “ОРДА Финанс ББСБ” ХХК-ийн 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлан

Мянган төгрөгөөр

Хөрөнгө		2022 оны 3-р улирал
Эргэлтийн хөрөнгө		2,151,910.90
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	58,905.50
1.2	Богино хугацаат хөрөнгө оруулалт (Цэврээр)	-
1.3	Зээл (Цэврээр)	1,628,553.70
	Нийт зээл	1,653,859.90
1.3.1	Нийт зээл (төгрөгийн)	1,635,056.30
	Хэвийн	1,270,451.20
	Анхаарал хандуулах	364,605.10
	Чанаргүй:	-
	Хэвийн бус	-
	Эргэлзээтэй	-
	Муу	-
1.3.2	Нийт зээл (валютын)	18,803.60
	Хэвийн	-
	Анхаарал хандуулах	-
	Чанаргүй:	18,803.60
	Хэвийн бус	18,803.60
	Эргэлзээтэй	-
	Муу	-
1.3.3	(Зээлийн эрсдлийн сан)	25,306.20
1.4	Бусад хөрөнгө	464,451.70
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	32,743.40
	Нийт авлага	16,368.30
	Бусад актив	415,340.00
Эргэлтийн бус хөрөнгө		6,243.10
2.1	Биет ба биет бус хөрөнгө (Цэврээр)	6,243.10
	Биет ба биет бус хөрөнгө	14,092.90
	Хуримтлагдсан элэгдэл	7,849.80
Нийт хөрөнгийн дүн		2,158,154.00

Мянган төгрөгөөр

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө		2022 оны 3-р улирал
1. Нийт өр төлбөр		151,263.20
1.1	Өр төлбөр	108,198.00
1.2	Бусад өр төлбөр	43,065.20
1.2.1	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	4,310.20
1.2.2	Бусад пассив	38,755.00
2. Эздийн өмч		2,006,890.80
2.1	Хувьцаат капитал	1,900,000.00
2.2	Бусад өмч	-
2.3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	106,890.80
Нийт өр төлбөр ба эздийн өмч		2,158,154.00

Хавсралт 2. “ОРДА Финанс ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000249067

2015.04.30 / Бүртгэсэн он, сар, өдөр / 9015003072 / Хувийн хэргийн дугаар /  
5960711 / Регистрийн дугаар /

Орда финанс ББСБ Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /  
Дүрэм / Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2015.04.29 / шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

6492 Зээл олгох үйл ажиллагаа / Код / / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 1,900,000.00 / хугацаа / / гишүүдийн тоо / / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, махатма ганди, 28 байр 605 тоот, Утас1: 99112148, Утас2: 75779444, Факс: / хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР  
/ Бүртгэсэн байгууллагын нэр /  
УЛСЫН БҮРТГЭГЧ Ш.ОЧИРСҮРЭН  
/ гэмдэгч / / гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 01 сар 11 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Ранчин овогтой Гантөмөр-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэж.	2021.12.03	Н.Донгоржав
2	Дахин гэрчилгээ олгож.	2022.01.11	Ш.Очирсүрэн
3	Алтанкундага овогтой Хэрлэнчимээ-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэж.	2022.08.22	Ш.Очирсүрэн

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000249067





## Хавсралт 4. Хүү бодох аргачлал

Хүүг тооцооллын томъёог дараах хүснэгтэд харуулав.

Хүүгийн хэмжээ = Үндсэн дүн \* Хүүгийн хувь \*  
Хугацаа / 365  
 $I = P * R * T / 365$   
I – Хүүгийн хэмжээ  
P – Үндсэн дүн  
R – Хүүгийн хувь  
T – Хугацаа

Нэмэгдүүлсэн хүү нь 10 хувь байна. Нэмэгдүүлсэн хүүг тооцох томъёог дараах хүснэгтэд үзүүлэв.

Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ = Эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн \* Хүү \* Нэмэгдүүлсэн хүүгийн хувь \* Хугацаа хэтэрсэн хоног

$$I_i = Pod * R * Ri * Tod / 365$$

$I_i$  - Нэмэгдүүлсэн хүү  
Pod - Эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн  
R – Хүү  
 $R_i$  - Нэмэгдүүлсэн хүүгийн хувь  
Tod- Хугацаа хэтэрсэн хоног

Бидэнтэй холбоо барих:

Утас: +976-75779444

И-мэйл: [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

Вэбсайт: [www.orda.mn](http://www.orda.mn)

---